



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 428

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан нийт 147,500,000.00 /нэг зуун дөчин долоон сая таван зуун мянган/ төгрөгийн балансын үнэ, 145,451,388.18 /нэг зуун дөчин таван сая дөрвөн зуун тавин нэгэн мянга гурван зуун наян найман төгрөг арван найман мянгэ/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээнцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Д.НАРАНГЭРЭЛ

900608

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн

498 дугаар тогтоолын хавсралт



Улсын Их Хурлын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
“Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт
балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкруйзер-200, 27-66 УБН, арал № JTMHХО5J18040445 77	2013/ 2013	147,500,000.00	145,451,388.18	2,048,611.82
	Нийт дүн		147,500,000.00 /нэг зуун дөчин долоон сая таван зуун мянган/	145,451,388.18 /нэг зуун дөчин таван сая дөрвөн зуун тавин нэгэн мянга гурван зуун наян найман төгрөг арван найман мөнгө/	2,048,611.82 /хоёр сая дөчин найман мянга зургаан зуун арван нэгэн төгрөг наян хоёр мөнгө/